

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2024 оны 08 сарын 12-ны өдөр

Дугаар БА-142/2024

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Сүхбаатар дүүргийн 7 дугаар хороонд баригдсан дунд төвөгшилтэй ангиллын зорьгүй 8 давхар, 1 блок хүчин чадал бүхий Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөгжлийн нэгдсэн төвийн зориулалттай барилга байгууламжид Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дүгээр захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 14 гишүүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2024 оны 06 дугаар сарын 03-ний өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1.Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний дугаар: 0010655 зөвшөөрлийн дугаар: 334/2022, огноо: 2022/05/24;

2.2.Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар: DL-02/2021;

2.3.Захиалагч: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам оноосон нэр, 9070004038 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 4 дүгээр хороо, Барилгачдын талбай, өөрийн байр, 260262, 263634 холбоо барих утас;

2.4.Барилгын ажил гүйцэтгэгч: Би Энд Би Констракшн ХХК оноосон нэр, 901121130 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5173345 регистрийн дугаар, БУ16-108/17 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 9 дүгээр хороо, Шинэ дэлхий цамхаг, 9-р давхар, 903 тоот, 99111704, 99886619 холбоо барих утас, info@himon.mn цахим хаяг;

2.5.Барилгын ажлын туслан гүйцэтгэгч байгууллага: Байхгүй.

2.6.Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: ЭМ ЭС ЭЛ ХХК оноосон нэр, 9011573077 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6021026 регистрийн дугаар, 3Т17-337/19 Барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 43 дугаар хороо, UB tower-1503 тоот, 75330088 холбоо барих утас, info@msl.mn цахим хаяг;

2.7.Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам оноосон нэр, 9070004038 Улсын бүртгэлийн

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗАР

Барилга байгууламжийг ашиглалтанд
оруулах комисс

гэрчилгээний дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 4 дүгээр хороо, Барилгачдын талбай, өөрийн байр, 260262, 263634 холбоо барих утас;

2.8.Барилга байгууламжийн төлөв байдал: Шаардлага хангасан.

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14,1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14,1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1.Энэ дунд төвөгшилтэй ангиллын зорьгүй 8 давхар, 1 блок хүчин чадал бүхий Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөгжлийн нэгдсэн төвийн зориулалттай барилга байгууламж түүний холбогдох баримт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж: үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2.Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбоотой ашиглалт захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь: **БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИСС**

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивд, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ,, , хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийн ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

3.3. Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.


3.4.Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 6 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 28 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох... хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1.Дунд төвөгшилтэй ангиллын зоорьгүй 8 давхар, 1 блок хүчин чадал бүхий Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөгжлийн нэгдсэн төвийн зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Сүхбаатар дүүргийн 7 дугаар хороо, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны захиалгатай, зоорьгүй 8 давхар Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөгжлийн нэгдсэн төвийн барилга

Комиссын дарга:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн дарга



/Ю.Оджаргал/

Нарийн бичгийн дарга:
Барилгын хөгжлийн төвийн
Барилга байгууламжийн захиалагчийн
хяналтын хэлтсийн дарга




/Э.Мөнхсүх/



Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.

БН
...лалтанд



Мэдээллийн санга бүртгэв.
Объектын дугаар: 508
Слос: 11.08.508
Бүртгэсэн: 2024.11.08
УЛААНБААТАР

СҮХБААТАР ДҮҮРГИЙН 7 ДУГААР ХОРОО, ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ЗАХИАЛГАТАЙ, ЗООРЬГҮЙ 8 ДАВХАР, 1 БЛОК
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ, ХӨГЖЛИЙН НЭГДСЭН ТӨВИЙН БАРИЛГЫГ
АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 06 дугаар сарын 03

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн 7 дугаар хороо, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны захиалгатай, зоорьгүй 8 давхар, 1 блок хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөгжлийн нэгдсэн төвийн барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын 3 дугаар давхрын хурлын зааланд 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр 13:30 цагт 14 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж 15:10 цагт дуусав.

Хуралд:

- | | |
|---|-----------------|
| 1. Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга | О.Оджаргал |
| 2. Хотын стандарт, хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс, Барилгын техникийн хяналтын улсын байцаагч | Б.Шинэжаргал |
| 3. Хотын стандарт, хяналт шалгалтын газрын Дэд бүтэц стандартын хяналтын хэлтэс, Эрчим хүч хяналтын улсын ахлах байцаагч | З.Очирпүрэв |
| 4. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК техник хяналтын инженер | Б.Дашдорж |
| 5. Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК БТГ-ийн ахлах инженер | Э.Ундрахцогт |
| 6. Ус сувгийн удирдах газар Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн инженер | С.Отгонтуяа |
| 7. Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК, Чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн | Н.Даваадэмид |
| 8. Онцгой байдлын ерөнхий газар, Гал түймрийн улсын хяналтын хэлтэс, Барилгын зураг төсөл хяналтын хэлтэс /дэд хурандаа/ | Ч.Артаг |
| 9. Барилгын хөгжлийн төв, Норм, нормативын хэлтсийн мэргэжилтэн | О.Ундрах |
| 10. Үндэсний төв архив, Зураг төслийн баримтын архивын эрхлэгч | Я.Чулуун |
| 11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах байгуулга, Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо, хүртээмжийн үнэлгээний ажилтан | Н.Эрдэнэтөгс |
| 12. Зураг зохиогч Эм эс эл ХХК-ийн инженер | Г.Мөнх-Оргил |
| 13. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга | М.Маргад-Эрдэнэ |
| 14. Гүйцэтгэгч байгуулга, Би энд би констракшн ХХК-ийн захирал | Ш.Энхтөр |

ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан-14



- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан-14

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Сүхбаатар дүүргийн 7 дугаар хороо, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны захиалгатай, зорьгүй 8 давхар, 1 блок хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөгжлийн нэгдсэн төвийн барилгыг ашиглалтад оруулах ажлын гүйцэтгэл шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс, Барилгын техникийн хяналтын улсын байцаагч **Б.Шинэжаргал:**

- Бетоны бат бэхийн шинжилгээний бичиг шалгуулах;
- Лифтний магадлал хийлгэж, улсын байцаагчийн албан шаардлагын биелэлт шалгуулах;
- Зураг төсөлд өөрчлөлт орсонтой холбоотой, Зохиогчоос гүйцэтгэлийн зураг гарсан эсэхийг эсэхийг шалгуулах;
- Зохиогч гүйцэтгэлд хяналт тавьсан акт шалгуулах;
- Улаан журнал шалгуулах;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Хяналт шалгалтын газрын Дэд бүтэц стандартын хяналтын хэлтэс, Эрчим хүч хяналтын улсын ахлах байцаагч **З.Очирпүрэв:**

- Гадна худаг, шат дулаалга цэвэрлэгээ хийх;
- Барилгын агаар сэлгэлтийн механик системүүдийн удирдлагын самбар бүрэн ажиллагаанд оруулан ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх;
- Хангагч байгууллагын үүрэг даалгавар биелүүлэх, термостат суурилуулах;
- Ашиглагч байгуулагд ХАС-ийн тоног төхөөрөмжийн зааварчилгаа өгч, бүрэн хүлээлгэж өгч акт-аар баталгаажуулах;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК техник хяналын инженер **Б.Дашдорж:**

- Гадна цахилгааны дэд өртөөг байнгын ашиглалтад оруулах комиссын акт дүгнэлт бичүүлж дуусгах ЦЭХ-ны гэрээ байгуулах;
- Дэд өртөөний өргөтгөлийн ашгаас буусан хуучин тоноглол трансформатор хүлээлгэж өгсөн акт шалгуулах;
- Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ тооцуулж зөвшөөрөл авах;
- Ерөнхий шийд болон давхар дундын шидэнд хаяг бичлэг биржүүлт хийх;
- Аянгын буулт холболт хийлгэж далд ажлын акт шалгуулах;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, БТГ-ийн ахлах инженер **Э.Ундрахцогт:**

- Гадна дулааны худаг цэвэрлэх ул цутгах, шат хийх;
- Хэрэгцээний халуун усны ялтсан бойлерын тоноглолын сертификат шалгуулах ачаалал тодорхой техникийн паспорт шалгуулах;
- ХХУ бойлерын 1-р хэлхээний буцах шугамд ус буулгагч хийх;
- 2-р хэлхээний даралтын даачиг, TCV температурын даачигийн зөв чигт суурилуулах;
- Хийм ус цэвэрлэгээний төхөөрөмжид химийн шингэн хийж ажилд оруулах;

- Үзлийн өрөөний тоноглолуудын будаг дулаалга гүйцээж хийх;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Ус сувгийн удирдах газар Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн инженер **С.Отгонтуяа:**

- Цэвэр усны худагт шат суурилуулах цэвэрлэх;
- Цэвэр усны тоолуур лацдуулах;
- Узелийн өрөөнд мэдээллийн самбар байршуулах;
- Бохир усны худагт шат суурилуулах цэвэрлэж лацдах;
- Цэвэр усны дээж шинжилгээнд хамруулах;
- Шугам сүлжээний хаягжуулалд хийх;
- Гадна худагт шугам гүйцээж дулаалах;
- Бохир усны худгийн хүзүүвч солих эсвэл тоосгон өрлөгтэй хэсгийг бетоноор өнгөлөх;
- Хуучин барилгын холболтыг хийхээр бэлдсэн байна УСУГ -аас зөвшөөрөл авч холбох;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК, Чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн **Н.Даваадэмид:**

- Холбооны өрөөг хаягжуулах;
- Гаднаас орж ирсэн кабель шугамд төгсгөлийн төхөөрөмж холболт хийх;
- Шилэн кабельд бирк зүүж төгсгөлийн төхөөрөмжид холбох;
- Зарлан мэдээлэх системийг бүрэн ажилд оруулах /бичлэг хийж шалгуулах/
- Давхарын самбар дээр хаягжилт хийх;
- Гадна холбооны худаг сувагчлалын байгууламжид стандарт таг хүзүү хийх;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Онцгой байдлын ерөнхий газар, Гал түймрийн улсын хяналтын хэлтэс, Барилгын зураг төсөл хяналтын хэлтэс, /дэд хурандаа/ **Ч.Артаг:**

- 1-р давхарт зургийн дагуу авто зогсоолд дулаан мэдрэгчийг бүрэн хийж Дулаан мэдрэгчийг шугам хоолойн дээгүүр хаасан байгааг засах;
- Галын дотор усны даралтад цэгийн холбох тотгийг гал унтраах багаж зэвсэглэлтэй холбож болохоор засах солих;
- Гадна дулаалга материал шинжилгээнд өгч дүгнэлт гаргуулах, ОБЕТ-ын Гамшиг судлалын үндэсний хүрээлэлд өгөх;
- Авто зогсоолд бие даасан гал унтраах систем төлөвлөх;
- Дулааны техникийн өрөөний дулаан мэдрэгчийг холбох;
- Өгсөн үүрэг даалгаврыг албан бичиг болон фото зургаар өгөх;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Барилгын хөгжлийн төв, Норм, нормативын хэлтсийн мэргэжилтэн **О.Ундрах:**

- Дээврийг зураг төсөлд мембрам гэж заасан, Хар цаасаар өөрчилсөн тухай зохиогчийн нэгдсэн дүгнэлтэд тусгаж ирүүлэх;
- Шатны хонгилын чулуун шат болон хулдаасан шалны уулзварын ам дарагч хийх эсвэл хулдаасны гагнаасыг сайжруулах;
- 1-р давхрын авто гражаас үйлчилгээний заал руу орж байгаа шилэн хаалгыг зураг төслийн дагуу хөнгөн цагаан металл хавтастай хаалгаар солих;
- БТХуулийн 5.7.1-д заасны дагуу гэрээ байгуулсан төсвийн хүрээнд НСШ төлөх;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Үндэсний төв архив, Зураг төслийн баримтын архивын эрхлэгч **Я.Чулуун**:

- Барилгын зураг төсөл баримт бичгийг бүрэн бүрэлдэхүүнээр эх хувиар архивд хүлээлгэж өгөх;
- Архивын заавар зөвлөмж журмын дагуу үндсэн баримтад дотоод товьёг үйлдэж,хуудас дугаарлан цэгцлэх;
- Төсвийн нэгжээс ажил эхлүүлэх зөвшөөрлийн эх хувийг авч хувийн хэрэгт хавсаргах;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах байгуулга, Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо, хүртээмжийн үнэлгээний ажилтан **Н.Эрдэнэтөгс**:

- Гадна явган хүний заманд Харааны бэрхшээлтэй хүний хөтөч зам хийх;
- Гадна авто зогсоолд ХБИ босоо тэмдэглэгээ хийх;
- 1 давхрын шалыг батлагдсан зургийн дагуу болгож халтиралтын түвшинг 0,11-т болгож засварлах;
- ХБИ Зориулсан ариун цэврийн өрөөг 1-8 давхар хүртэл стандартын дагуу ХБИ ашиглахад аюулгүй тоноглолоор угаалтуур суултуур 1,1 шээлтүүрийг тоноглох /эр/;
- Шалны эхлэл ба төгсөх хэсгүүд дээр сул хараатай болон харааны бэрхшээлтэй хүнд мэдрэгдэхээр стандартын дагуу тартель зам тод өнгийн резин нь материал нааж өгөх;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Зураг зохиогч, Эм эс эл ХХК-ийн инженер **Г.Мөнх-Оргил**:

- Голын шатны хашлага хийцийг зэврэлтээс хамгаалж 1 үе ахиж будах;
- Шатны хонгилын чулуун маршан дээр R11 зэрэгтэй хулдаас нэмж наах;
- ХБИ -ийн АЦӨ ний тоноглол бариулын зураг төслийн дагуу хийх;
- Гадна явган замын хавтанг зураг төслийн дагуу хийх;
- Авто гражийн ХБИ зогсоолын тэмдэглэгээг зураг төслийн дагуу засварлах;
- Ашиглагч байгууллага тухайн барилгийг хариуцсан ИТА -н яаралтай томилон ажиллуулах, гүйцэтгэгч байгууллагаас ашиглалт хариуцсан ИТА-д дуудлага дохио системийн талаар нарийвчилсан зааварчилгаа өгөх;
- Самбаруудад бирк хийж скем наах;
- Аянга хүлээн авагчийн тоноглолын зориулалтын хөндийрүүлэгч, холбогч боолт ашиглаж засварлах;
- Халаах хэрэгслийн термостат хаалтуудыг суурилуулах;
- Системийн /агаар сэлгэлт / удирдлагыг тохируулж дуусгах;
- Ил гарсан агаар сэлгэлтийн хоолойн заслын ажилтай уялдуулан будах;
- АЦӨ-ийн бохирын шалгах тагийг засварлах;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга **М.Маргад-Эрдэнэ**:

- Нийт комиссын гишүүдийн үүрэг даалгаврыг биелүүлэх;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Барилгын ажлын гүйцэтгэгч Би Энд Би Констракшн' ХХК-ийн захирал **Ш.Энхтөр**:

- Гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Комиссын дарга: Хяналт шалгалтын газар, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга **О.Оджаргал**:

- БНБД 11-04-16 дагуу зохиогч дүгнэлт бичих;
- БТХ-ийн дагуу барилгад чанарын баталгаа гаргаж албан тоотоор ирүүлэх;

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:


Сүхбаатар дүүргийн 7 дугаар хороо, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны захиалгатай, зоорьгүй 8 давхар, 1 блок хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөгжлийн нэгдсэн төвийн барилгыг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлт үйлдэх, баталгаажуулах, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:

Хяналт шалгалтын газар,

Барилга байгууламжийн ашиглалт,

бүртгэлийн хэлтсийн дарга: **О.Оджаргал**



Тэмдэглэл хөтөлсөн:

Барилгын хөгжлийн төв,

Барилга байгууламжийн захиалагчийн

хяналтын хэлтсийн дарга **Э.Мөнхсүх**

